

## ГАРЧИГ

### МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

84.	Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	326
85.	Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	327
86.	Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай	327
87.	Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	328
88.	Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	329

### МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

89.	Танхимиын тэргүүнээр томилох тухай	Дугаар 01	329
90.	Шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай	Дугаар 13	330
91.	Монгол судлалыг дэмжих сан байгуулах тухай	Дугаар 14	330

### МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

92.	Мэргэжлийн боловсрол, сургалтын үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүн батлах тухай	Дугаар 327	331
93.	Эрүүл мэндийн даатгалын 2012 оны шимтгэлийн хэмжээг тогтоох тухай	Дугаар 328	333
94.	Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Дугаар 333	333
95.	Төрийн өмчит үйлдвэрийн газар байгуулах тухай	Дугаар 335	334



96.	Тогтоолд өөрчлөлт оруулах тухай	Дугаар 337	335
97.	Журам батлах тухай	Дугаар 339	336
98.	Журам батлах тухай	Дугаар 340	341
99.	“100 мянган айлын орон сууц” хөтөлбөрийг хэрэгжүүлэх тухай	Дугаар 341	352
100.	Төлөвлөгөө батлах тухай	Дугаар 342	361
101.	Журам батлах тухай	Дугаар 344	365
102.	Журам батлах тухай	Дугаар 345	366

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 01 дүгээр  
сарын 13-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ДЭЭД БОЛОВСРОЛЫН САНХҮҮЖИЛТ, СУРАЛЦАГЧДЫН НИЙГМИЙН БАТАЛГААНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуулийн 11 дүгээр зүйлд дор дурдсан агуулгатай 11.3 дахь хэсэг нэмсүгэй:

“11.3. Засгийн газраас тодорхойлсон дээд боловсролын салбарын талаар баримтлах чиглэл, шаардлагад нийцүүлэн төсөл, хөтөлбөрийг сонгон шалгаруулах, санхүүжүүлэх журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батална.”

**2 дугаар зүйл.** Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4 дэх хэсгийн “5.3.1, 5.3.2-т” гэснийг, 5.8 дахь хэсгийн “5.3.2-т” гэснийг “11.3-т” гэж тус тус өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.** Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4 дэх хэсгийн “нийлбэр” гэснийг хассугай.

**4 дүгээр зүйл.** Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3.1, 5.3.2, 5.3.4 дэх заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.



**5 дугаар зүйл.** Энэ хуулийг 2012 оны 01 дүгээр сарын 13-ны өдрөөс эхлэн дагаж мөрднө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 01 дүгээр  
сарын 13-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2, 16.3 дахь хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“16.2.Төсвийн ерөнхийлөн захирагч нь тухайн жилд суралцагчид олгох санхүүгийн дэмжлэгт хамрагдах суралцагчдын тоо, сургалтын төлбөрийн хүшиг хэмжээг харгалзан энэ хуулийн 16.1-д заасан санд улсын төсвөөс олгох хөрөнгийн хэмжээг төлөвлөнө.

16.3.Энэ хуулийн 16.1-д заасан сангийн хөрөнгийг улсын төсвөөс хуваарилсан хэмжээгээр Засгийн газраас тогтоосон журмын дагуу суралцагчид үзүүлэх санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулна.”

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг 2012 оны 01 дүгээр сарын 13-ны өдрөөс эхлэн дагаж мөрднө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 01 дүгээр  
сарын 19-ний өдөр

Улаанбаатар  
хот

### ЗАСГИЙН ГАЗРЫН АГЕНТЛАГИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 5.6 дахь хэсэг нэмсүгэй:

“5.6.Агентлагийн чиг үүрэг, үзүүлэх үйлчилгээ, үйл ажиллагааны хамрах хүрээг харгалzan түүний байршлыг Засгийн газар тогтооно.”

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг 2012 оны 01 дүгээр сарын 19-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

### МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 01 дүгээр  
сарын 19-ний өдөр

Улаанбаатар  
хот

### НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** 2008 оны 5 дугаар сарын 29-ний өдөр баталсан Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуульд дор дурдсан агуулгатай 2 дугаар зүйл нэмсүгэй:

**“2 дугаар зүйл.** Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөгдхөн трактор, комбайн, машин механизм, бусад техник, тоног төхөөрөмж, бордоо, ургамал хамгааллын бодисын жагсаалтыг “Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем /БТКУС/-ийн ангиллын дагуу Засгийн газар батална.”

**2 дугаар зүйл.** 2008 оны 5 дугаар сарын 29-ний өдөр баталсан Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн 1 дүгээр зүйлийн “оруулж байгаа” гэсний дараа “болон дотооддоо худалдан борлуулсан” гэж, “тоног төхөөрөмж,” гэсний дараа “оин аж ахуйн техник, тоног төхөөрөмж,” гэж тус тус нэмсүгэй.

**3 дугаар зүйл.** 2008 оны 5 дугаар сарын 29-ний өдөр баталсан Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн 1 дүгээр зүйлийн “2011” гэснийг “2016” гэж, 2 дугаар зүйлийн дугаарыг “3” гэж тус тус өөрчилсүгэй.

**4 дүгээр зүйл.** Энэ хуулийг 2011 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 01 дүгээр  
сарын 19-ний өдөр

Улаанбаатар  
хот

### ГААЛИЙН АЛБАН ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** 2008 оны 5 дугаар сарын 29-ний өдөр баталсан Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуульд дор дурдсан агуулгатай 2 дугаар зүйл нэмсүгэй:

**“2 дугаар зүйл.** Гаалийн албан татвараас чөлөөлөгдөх трактор, комбайн, машин механизм, бусад техник, тоног төхөөрөмж, бордоо, ургамал хамгааллын бодисын жагсаалтыг “Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем /БТКУС/-ийн ангиллын дагуу Засгийн газар батална.”

**2 дугаар зүйл.** 2008 оны 5 дугаар сарын 29-ний өдөр баталсан Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн 1 дүгээр зүйлийн “тоног төхөөрөмж,” гэсний дараа “оин аж ахуйн техник, тоног төхөөрөмж,” гэж нэмсүгэй.

**3 дугаар зүйл.** 2008 оны 5 дугаар сарын 29-ний өдөр баталсан Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн 1 дүгээр зүйлийн “2011” гэснийг “2016” гэж, 2 дугаар зүйлийн дугаарыг “3” гэж тус тус өөрчилсүгэй.

**4 дүгээр зүйл.** Энэ хуулийг 2011 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөс эхлэн дагаж мөрднө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2012 оны 01 дүгээр  
сарын 06-ны өдөр

Дугаар 01

Улаанбаатар  
хот

### Танхимын тэргүүнээр томилох тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, Шүүхийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.7 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

- Сандагийн Нямжавыг Монгол Улсын Дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын тэргүүнээр томилсугай.

2. Бүрэн эрхийн хугацаа нь дуусгавар болсонтой холбогдуулан Даваажавын Батсайханыг Монгол Улсын Дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын тэргүүнээс чөлөөлсүгэй.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ

Ц.ЭЛБЭГДОРЖ

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2012 оны 01 дүгээр  
сарын 16-ны өдөр

Дугаар 13

Улаанбаатар  
хот

### Шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, Шүүхийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн тул Райханы Асхабылийг Баян-Өлгий аймгийн шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалаас чөлөөлсүгэй.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ

Ц.ЭЛБЭГДОРЖ

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2012 оны 01 дүгээр  
сарын 17-ны өдөр

Дугаар 14

Улаанбаатар  
хот

### Монгол судлалыг дэмжих сан байгуулах тухай

“Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 3.1.4 дүгээр зүйл болон “Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлал”-ын 23.5; 24; 25.5 дахь заалтыг хэрэгжүүлэх, эх түүх, үндэсний соёлын өв санггаа өргөн хүрээнд судлах, нээн илрүүлэх, баталгаажуулах, судалгааны эрглэлтэд оруулах, энэхүү ажилд гадаад орны эрдэмтдийг татан оролцуулах, тэдэнтэй нягт хамтран ажиллах, Монгол Улсад болон гадаад оронд монгол судлалыг хөхиүлэн дэмжих, монгол судлалыг хөрөнгө санхүүгийн хувьд ивээн тэтгэх замаар эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг идэвхжүүлэх, залуу судлаачдыг урамшуулах, тэдний бүрэлдэхүүнийг бэлтгэх, чадавхижуулах, монгол судлалын үр өгөөжийг нэмэгдүүлэх, дэлхий дахинд сурталчлах зорилгоор Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх



хэсгийн 3 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12 дахь хэсгийг баримтлан ЗАРЛИГ БОЛГОХ нь:

1. Монгол судлалыг дэмжих сан байгуулж ажиллуулахыг Монгол Улсын Засгийн газар (Ерөнхий сайд С.Батболд)-т чиглэл болгосугай.

2. Гадаадын монгол судлаачдыг бэлтгэх, мэргэшүүлэх зорилгоор докторын судалгаа-сургалтыг зохион байгуулахыг Монгол Улсын Шинжлэх ухааны академид зөвлөмж болгосугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ

ЦАХИАГИЙН ЭЛБЭГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД

СҮХБААТАРЫН БАТБОЛД

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2011 оны 11 дүгээр  
сарын 16-ны өдөр

Дугаар 327

Улаанбаатар  
хот

### Мэргэжлийн боловсрол, сургалтын үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүн батлах тухай

Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 6.4-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Засгийн газрын комисс, хороо, үндэсний зөвлөл, ажлын хэсгийн бүрэлдэхүүний тухай” Засгийн газрын 2009 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн 82 дугаар тогтоолын 21 дүгээр хавсралтаар баталсан Мэргэжлийн боловсрол, сургалтын үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг хавсралт ёсоор өөрчлөн баталсугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Засгийн газрын 2009 оны 7 дугаар сарын 1-ний өдрийн 196 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД

С.БАТБОЛД

БОЛОВСРОЛ, СОЁЛ,  
ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД

Ё.ОТГОНБАЯР

Засгийн газрын 2011 оны 327 дугаар  
тогтоолын хавсралт

Засгийн газрын 2009 оны 82 дугаар  
тогтоолын 21 дүгээр хавсралт

## МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ

Дарга	-Монгол Улсын Шадар сайд
Орлогч дарга	-Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбооны гүйцэтгэх захирал (тохиролцсоноор)
Гишүүд:	<ul style="list-style-type: none"><li>-Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга;</li><li>-Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга;</li><li>-Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;</li><li>-Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;</li><li>-Эрдэс баялаг, эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга;</li><li>-Сангийн яамны Төсвийн бодлогын газрын дарга;</li><li>-Зэвсэгт хүчний Жанжин штабын дэд дарга;</li><li>-Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга;</li><li>-Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын Бизнес, гадаад худалдаа, сургалт, судалгааны газрын дарга (тохиролцсоноор);</li><li>-Монголын үйлдвэрчний эвлэлтүүдийн холбооны ерөнхийлөгч (тохиролцсоноор);</li><li>-Монголын барилгачдын холбооны ерөнхийлөгч (тохиролцсоноор);</li><li>-Монголын хүнсчдийн холбооны ерөнхийлөгч (тохиролцсоноор);</li><li>-Бизнесийн зөвлөлийн дэд захирал (тохиролцсоноор);</li><li>-Монголын уул уурхайн ассоциацийн бодлогын шинжээч (тохиролцсоноор);</li><li>-Техникийн болон мэргэжлийн сургуулиудын холбооны тэргүүн (тохиролцсоноор);</li><li>-Мэргэжлийн боловсрол, сургалтын газрын дарга</li></ul>
Нарийн бичгийн дарга	



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2011 оны 11 дүгээр  
сарын 16-ны өдөр

Дугаар 328

Улаанбаатар  
хот

### Эрүүл мэндийн даатгалын 2012 оны шимтгэлийн хэмжээг тогтоох тухай

Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 8.1.1, 8.1.3-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. 2012 онд аж ахуйн нэгж, байгууллагын ажилтны сар тутам төлөх эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хувь, хэмжээг түүний хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын 4 хувь байхаар тогтоосугай.

2. Төрөөс эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг хариуцдаг даатгуулагчийн сарын шимтгэлийн хэмжээг 670 төгрөгөөр, их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн өдрийн ангийн суралцагч, малчин, ял эдэлж байгаа хоригдол, Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 6.1.11-д заасан иргэний эрүүл мэндийн даатгалын сарын шимтгэлийн хэмжээг 670 төгрөгөөр, гадаадын иргэн, харьяалалгүй хүний сарын шимтгэлийн хэмжээг хөдөлмөрийн хөлслний доод хэмжээний 6 хувь байхаар тус тус тогтоож 2012 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдүүлсүгэй.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Эрүүл мэндийн даатгалын 2011 оны шимтгэлийн хэмжээг тогтоох тухай” Засгийн газрын 2010 оны 12 дугаар сарын 29-ний өдрийн 346 дугаар тогтоолыг 2012 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД

С.БАТБОЛД

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД

С.ЛАМБАА

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2011 оны 11 дүгээр  
сарын 23-ны өдөр

Дугаар 333

Улаанбаатар  
хот

### Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Дотоодын цэргийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 5-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Засгийн газрын 2004 оны 5 дугаар сарын 26-ны өдрийн 135 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Цагдаа, дотоодын цэргийн хамгаалалтад байх объектын жагсаалт”-ын Нэг дэх хэсэгт “16. Ховд хотын ус хангамжийн эх үүсвэр”, “17. Дөргөний усан цахилгаан станц”, “18. Эрдэнэт хотын ус хангамжийн эх үүсвэр”, “19. Даланзадгад хотын ус хангамжийн эх үүсвэр”, “20. “Дулааны III цахилгаан станц”, “Дулааны IY цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компаниуд”, “21. Татварын өрөнхий газрын төв байр” гэж, мөн хавсралтын Гурав дахь хэсэгт “4. Нарantuул олон улсын худалдааны төв, Да хүрээ автотехникийн зах”, “5. Тавантолгойн нүүрсний уурхайн бүс нутаг, тээвэрлэлтийн зам, Оюу толгойн зэс, алтны ордын бүс нутаг”; “6. Уулын баяжуулах “Эрдэнэт” үйлдвэр” гэж тус тус нэмсүгэй.

2. Мөн хавсралтын Хоёр дахь хэсгийн 1, 3 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

3. Ховд, Эрдэнэт, Даланзадгад хотын ус хангамжийн эх үүсвэр, Дөргөний усан цахилгаан станц, “Дулааны III цахилгаан станц”, “Дулааны IY цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компаниуд, Татварын өрөнхий газрын төв байрыг дотоодын цэргийн төсөвт хамгаалалтад авсантай холбогдуулан эдгээр объектын хамгаалалтын зардалд шаардагдах хөрөнгийг жил бурийн улсын төсөвт тусган санхүүжүүлж байхыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж, Сангийн сайд С.Баярцогт нарт даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**С.БАТБОЛД**

**ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД  
ХЭРГИЙН САЙД**

**Ц.НЯМДОРЖ**

**САНГИЙН САЙД**

**С.БАЯРЦОГТ**

## **МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ**

2011 оны 11 дүгээр  
сарын 23-ны өдөр

Дугаар 335

Улаанбаатар  
хот

**Төрийн өмчит үйлдвэрийн газар  
байгуулах тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 5, Усны тухай хуулийн 36.7, Улсын Их Хурлын 2010 оны 24 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:



1. Усны нөөцийн менежмент хийх, төрийн эзэмшлийн болон төсвийн хөрөнгөөр баригдсан усны барилга байгууламж, түүний дотор толгойн байгууламжийн ашиглалт, засвар үйлчилгээг хариуцан ажиллах чиг үүрэг бүхий “Монгол Ус” төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрыг байгуулсугай.

2. “Монгол Ус” төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын дүрмийг баталж мөрдүүлэхийг Төрийн өмчийн хороо (Д.Сугар), үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Л.Гансүхэд даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**С.БАТБОЛД**

**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ  
ЖУУЛЧЛАЛЫН САЙД**

**Л.ГАНСҮХ**

## **МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ**

2011 оны 11 дүгээр  
сарын 23-ны өдөр

Дугаар 337

Улаанбаатар  
хот

### **Тогтоолд өөрчлөлт оруулах тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

“Шинэ бүтээн байгуулалт” хөтөлбөрийн хүрээнд хот байгуулалт, барилгын салбарт авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2011 оны 5 дугаар сарын 3-ны өдрийн 149 дүгээр тогтоолын 1 дүгээр зүйлийн “Шууд гэрээ байгуулан гүйцэтгэх дулаан хангамжийн түгээх шугам сүлжээний угсралтын ажлын жагсаалтыг 1 дүгээр, цахилгаан дулааны эх үүсвэр, дамжуулах сүлжээний барилга байгууламжийн ажлын жагсаалтыг 2 дугаар” гэснийг “Нээлттэй тендер шалгаруулалтын аргыг хэрэглэн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулан гүйцэтгэх дулаан хангамжийн түгээх шугам сүлжээний угсралтын ажлын жагсаалтыг 1 дүгээр, Нээлттэй тендер шалгаруулалтын аргыг хэрэглэн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах цахилгаан дулааны эх үүсвэр, дамжуулах сүлжээний барилга байгууламжийн ажлын жагсаалтыг 2 дугаар” гэж, мөн тогтоолын 1 дүгээр хавсралтын нэрийг “Нээлттэй тендер шалгаруулалтын аргыг хэрэглэн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах дулаан хангамжийн түгээх шугам сүлжээний угсралтын ажлын жагсаалт” гэж, 2 дугаар хавсралтын

нэрийг “Нээлттэй тендер шалгаруулалтын аргыг хэрэглэн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах цахилгаан, дулааны эх үүсвэр, дамжуулах сүлжээний барилга байгууламжийн ажлын жагсаалт” гэж тус тус өөрчилсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**С.БАТБОЛД**

**ЭРДЭС БАЯЛАГ,  
ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД**

**Д.ЗОРИГТ**

## **МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ**

2011 оны 11 дүгээр  
сарын 30-ны өдөр

Дугаар 339

Улаанбаатар  
хот

### **Журам батлах тухай**

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 11.5-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохио дамжуулах журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.
2. Энэ журмыг хэрэгжүүлж ажиллахыг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.
3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Иргэний хамгаалалтын тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 1994 оны 9 дүгээр сарын 28-ны өдрийн 170 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**С.БАТБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН  
ШАДАР САЙД**

**М.ЭНХБОЛД**



Засгийн газрын 2011 оны 339 дүгээр  
тогтооолын хавсралт

## ГАМШГИЙН АЮУЛЫН ТУХАЙ ЗАРЛАН МЭДЭЭЛЛИЙН ДОХИО ДАМЖУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийг бүх нийтэд үнэн зөв, шуурхай хүргэх, удирдлагын мэдээллийн нэгдсэн тогтолцоо бүрдүүлэх, төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг тогтоосон дохиогоор ажиллах арга ажиллагаанд сургаж дадлагажуулах ажлыг зохион байгуулахад энэ журмыг дагаж мөрднө.

1.2. Гамшгийн аюулаас хүн ам, эд хөрөнгийг урьдчилан сэргийлэх, аврах, хор уршигийг арилгах, хойшилуулшгүй сэргээн босгох үйл ажиллагааны үе шатанд гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, аж ахуйн нэгж, байгууллага, сайн дурынхны хүч хэрэгслийг ашиглах болон иргэд, олон нийтийг гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэргүүдэд шилжүүлэн ажиллуулах зорилгоор онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийг зохион байгуулна.

1.3. Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийг Гамшгаас хамгаалах тухай хуулийн 11.4-т заасны дагуу дамжуулна.

1.4. Аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хороо, аж ахуйн нэгж, байгууллага нь хүн ам, нутаг дэвсгэр, үйл ажиллагааныхаа онцлогт тохирсон зарлан мэдээлэл дамжуулах хэрэгсэлтэй байна.

Хоёр. Гамшгийн аюулын тухай зарлан  
мэдээлэл, түүний ангилал

2.1. “Гамшгийн аюулын тухай зарлан мэдээлэл” гэж хүн амд учирч болзошгүй гамшгийн аюулын тухай дохио, сээрэмжлүүлэх мэдээллийг төвлөрсөн мэдээллийн хэрэгсэл, тусгай хэрэглээний холбоо, орон нутгийн болон олон нийтийн радио, телевиз, мэдээлэл, харилцаа холбооны бүх төрлийн хэрэгсэл (цаашид “зарлан мэдээллийн хэрэгсэл” гэнэ)-ээр нэн даруй хүргэхийг хэлнэ.

2.2. Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийг дараах байдлаар ангилна:

- 2.2.1. гамшгийн аюулын тухай дохио;
- 2.2.2. сээрэмжлүүлэх мэдээлэл.



2.3. "Гамшгийн аюулын тухай дохио" гэж аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой осол, алан хядах ажиллагаа, дэлбэрэлтийн улмаас үүссэн гамшгийн хохирлыг бууруулж, хүний амь нас, эрүүл мэнд, мал, амьтан, хүрээлэн буй орчин, эд хөрөнгийг хамгаалах зорилгоор бий болсон нөхцөл байдлыг зарлан мэдээллийн хэрэгслээр богино хугацаанд оновчтой хэлбэрээр мэдээлэхийг хэлнэ.

2.4. "Сэргэмжлүүлэх мэдээлэл" гэж мэргэжлийн байгууллагын дүгнэлт, мэдээллийн үндсэн дээр болзошгүй эрсдэлээс сэргийлэх зорилгоор зарлан мэдээллийн хэрэгслээр урьдчилан мэдээлэхийг хэлнэ.

2.5. Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийг төрлөөр нь дараахь байдлаар ангилна:

- 2.5.1. бүх нийтийн;
- 2.5.2. хэсэгчилсэн.

2.6. "Бүх нийтийн зарлан мэдээлэл" гэж засаг захиргаа нутаг дэвсгэрийн хэд хэдэн нэгжид үүссэн буюу үүсэж болзошгүй гамшгийн тухай мэдээллийг орон даяар зарлан мэдээллийн хэрэгслээр хүргэхийг хэлнэ.

2.7. "Хэсэгчилсэн зарлан мэдээлэл" гэж сум, дүүрэг, аймгийн нутаг дэвсгэрт буюу түүний зарим хэсэгт үүссэн буюу үүсэж болзошгүй гамшгийн тухай мэдээллийг зарлан мэдээллийн хэрэгслээр хүргэхийг хэлнэ.

Гурав. Гамшгийн аюулын тухай зарлан  
мэдээлэл дамжуулах хүч хэрэгсэл

3.1. Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийг дараахь техник хэрэгсэл, сүлжээ, хүн хүчийг ашиглан дамжуулна:

3.1.1. төвлөрсөн зарлан мэдээллийн хэрэгсэл (дуут дохионы хамт тэмдэг, дохио, бичиг, дуут мэдээлэл хэлбэрээр);

3.1.2. тусгай хэрэглээний холбоо (радио, телефон суваг болон мэдээллийн сүлжээгээр дуу, бичиг хэлбэрээр);

3.1.3. олон нийтийн болон орон нутгийн радио, телевизийн сүлжээ (дуут дохионы хамт дуу, бичлэг болон хөдөлгөөнт үсгэн мэдээлэл хэлбэрээр, телевизийн мэдээллийг дохионы хэлний орчуулгатай гаргах, бичгэн мэдээллийг хараагүй хүнд зориулж нэвтрүүлэгч унших);

3.1.4. цахилгаан холбооны сүлжээ (дуу, бичиг хэлбэрээр);



3.1.5. радио холбооны сүлжээ (онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллага болон үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагын хэмжээнд радио сувгаар тэмдэгт, дохио, дуу, дурс болон бусад хэлбэрээр);

3.1.6. үүрэн телефон холбооны сүлжээ (тусгай зарлан мэдээллийн сувгаар бүх хэрэглэгчдэд нэгэн зэрэг нэгдсэн мессеж хэлбэрээр);

3.1.7. цахим мэдээллийн сүлжээ (олон нийтийн мэдээллийн сайтуудын эхний нүүрэнд нэгэн зэрэг нэгдсэн цахим хэлбэрээр);

3.1.8. аймаг, нийслэл, сум, дүүрэг, аж ахуйн нэгж, байгууллагын зарлан мэдээллийн хэрэгсэл, дотоод холбооны төхөөрөмж, мэдээллийн дэлгэц, төрөл бүрийн дохиоллын хэрэгсэл, тээврийн хэрэгсэл, чанга яригч;

3.1.9. бие холбоочин (зарлан мэдээллийн хэрэгсэл байхгүй, эсхүл гэмтэл гарч сэргээх боломжгүй болсон тохиолдолд тухайн байгууллагын дотоод журамд зааж бие холбоочин томилно).

**Дөрөв. Гамшгийн тухай зарлан мэдээлэл  
дамжуулах зохион байгуулалт**

4.1. Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага улс орны хэмжээнд зарлан мэдээллийн сүлжээг шинээр байгуулах, өргөтгэл, шинэчлэл хийх, бэлэн байдлыг хангах, сүлжээн доторхи харилцаан ажиллагаа, техникийн үйлчилгээг хийх ажлыг Мэдээлэл, харилцаа холбооны улсын алба, Харилцаа холбооны зохицуулах хороотой хамтран зохион байгуулна.

4.2. Мэдээлэл, харилцаа холбооны улсын алба нь зарлан мэдээллийн сүлжээг байнгын бэлэн байдалд байлгаж, шугам, тоног төхөөрөмж, техник хэрэгслийг өргөтгэх, шинэчлэх, гамшгийн үед гарч болзошгүй эрсдэлийг урьдчилан тооцож чухал шаардлагатай тоног төхөөрөмжийг нөөцөд авч, үйлчилгээний зориулалт болон газрын байршилыг өөрчлөх, түр зогсоох үед онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад урьдчилан мэдэгднэ.

4.3. Гамшгийн аюулын тухай зарлан мэдээлэл дамжуулах шийдвэрийг дор дурдсанаар гаргаж, нэн даруй зохион байгуулна:

4.3.1. сум, дүүрэг, аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрт буюу түүний зарим хэсэгт үүссэн болон үүсэж болзошгүй гамшгийн үед



тухайн шатны гамшигаас хамгаалах алба, мэргэжлийн байгууллагын санал, дүгнэлтийг үндэслэн сум, дүүрэг, аймаг, нийслэлийн Засаг даргын шийдвэрээр зарлан мэдээллийн хэрэгслээр;

4.3.2. аймаг, нийслэл болон хэд хэдэн аймаг, дүүргийн нутаг дэвсгэрт үүссэн буюу үүсэж болзошгүй гамшигийн үед гамшигаас хамгаалах улсын алба, мэргэжлийн байгууллагын санал, дүгнэлтийг үндэслэн гарсан Монгол Улсын Засгийн газрын шийдвэрээр зарлан мэдээллийн хэрэгслээр;

4.3.3. шаардлагатай тохиолдолд онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд, онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын даргын шийдвэрээр тус газрын Шуурхай удирдлагын ерөнхий зохицуулагч зарлан мэдээллийн хэрэгслээр энэ журмын 2.5-д заасан төрлүүдээр гамшигийн аюулын тухай зарлан мэдээллийг хүргэж, шуурхай удирдан зохион байгуулна.

4.4. Гамшигийн аюулын тухай зарлан мэдээлэлд тухайн бүс, нутаг дэвсгэрт үүссэн буюу үүсэж болзошгүй гамшиг, газар орны зааг, учирсан хохирлыг арилгах үйл ажиллагаа, үргэлжлэх хугацаа, иргэд болон нийтээр мөрдөх ажиллах горим, бусад шаардлагатай мэдээллийг зарлан мэдээллийн хэрэгслийг ашиглан нийтэд мэдээлж болно.

4.5. Гамшигийн аюулын тухай зарлан мэдээлэл дамжуулсан үед онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь харьяа салбар нэгж, олон нийтийн болон орон нутгийн радио, телевиз, мэдээлэл, харилцаа холбооны албан мэдээлэл дамжуулах үйл ажиллагаанд хяналт тавьж шуурхай удирдлагаар хангаж ажиллана.

#### Тав. Бусад зүйл

5.1. Онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллаас жил бүрийн 3 дугаар сарын дөрөв дэх долоо хоногийн пүрэв гарагийн 16.00 цагт улс орон даяар гамшигийн аюулын тухай зарлан мэдээллийн дадлага, сургалт хийж, бэлэн байдлыг хангаж ажиллана.

5.2. Төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагын дарга, захирал гамшигийн тухай зарлан мэдээллийг хүлээн авмагц тухайн байгууллагад мөрдөх журам, батлагдсан төлөвлөгөөний дагуу байгууллага болон харьяа нэгжийнхээ хэмжээнд өөрийн зарлан мэдээллийн хэрэгслээр тодорхой давталттайгаар зарлан мэдээлэх ажлыг зохион байгуулна.

5.3. Гамшигийн аюулын тухай зарлан мэдээлэл, сээрэмжлүүлэх мэдээллийг саатуулах, дамжуулахгүй байх, мэдээллийг бизнесийн болон хувийн зорилгоор ашигласан байгууллага, албан тушаалтан, иргэнд хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2011 оны 11 дүгээр  
сарын 30-ны өдөр

Дугаар 340

Улаанбаатар  
хот

### Журам батлах тухай

Гамшигаас хамгаалах тухай хуулийн 9.8-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Гамшигийн үед хүч хэрэгсэл дайчлан гаргах журам"-ыг 1 дүгээр, "Гамшигийн үед нүүлгэн шилжүүлэх журам"-ыг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Журам, жагсаалт батлах тухай" Засгийн газрын 1997 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 107 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД

С.БАТБОЛД

МОНГОЛ УЛСЫН  
ШАДАР САЙД

М.ЭНХБОЛД

Засгийн газрын 2011 оны 340 дүгээр  
тогтоолын 1 дүгээр хавсралт

### ГАМШГИЙН ҮЕД ХҮЧ ХЭРЭГСЭЛ ДАЙЧЛАН ГАРГАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмаар гамшигийн үед аврах, учирсан хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагааг хэрэгжүүлэх зорилгоор хүн хүч, техник хэрэгслийг татан оролцуулахтай холбоотой харилцааг зохицуулна.

1.2. Гамшигийн аюулын цар хэмжээ, нөхцөл байдал, хамарсан хүрээ, учруулах хор уршгаас шалтгаалж шаардлагатай хүн хүч, техник хэрэгслийг дайчлан гаргах ажлыг бүх шатны Засаг дарга хариуцан зохион байгуулна.

1.3. Гамшигаас хамгаалах дайчилгаанд гамшигаас хамгаалах чиг үүрэг бүхий албад, аж ахуйн нэгж, байгууллага, дүйцүүлэх албаны алба хаач, мэргэжлийн анги, иргэд болон сайн дүрүнхан хамрагдана.



1.4. Шаардлагатай гэж үзсэн тохиолдолд зэвсэгт хүчнийг татан оролцуулах асуудлыг Гамшигаас хамгаалах тухай хуулийн 9.9-д заасны дагуу шийдвэрлүүлнэ.

1.5. Эрэн хайх, аврах, сэргээн босгох ажиллагаанд оролцооор ирж байгаа олон улсын аврах багийн хүн хүч, техник, тоног төхөөрөмж, хүмүүнлэгийн тусламжийг улсын хилээр холбогдох хуулийн дагуу бүрдүүлэлт хийж оруулна.

1.6. Энэхүү журмыг бүх шатны Засаг дарга, төрийн болон төрийн бус байгууллага, албан тушаалтан, өмчийн хэлбэр харгалзахгүйгээр аж ахуйн нэгж болон иргэд дагаж мөрднө.

**Хоёр. Гамшигаас хамгаалах дайчилгаа  
зарлах тухай**

2.1. Гамшигаас хамгаалах дайчилгааг зарлах шийдвэрийг дараахь тохиолдолд гаргана:

2.1.1. тухайн газар нутагт техникийн холбогдолтой осол, газар хөдлөлт, дэлбэрэлт, цацраг идэвхт бодис болон химийн хорт бодис алдагдсанаас хүн ам, мал, амьтан амьдрах орчингүй болсон;

2.1.2. хүн ам, мал, амьтны болон олон улсын хөл хориот халдварт өвчин үүссэн, уг голомтын зэргэлдээ орших суурин газрын хүн ам, мал, амьтныг урьдчилан сэргийлэх зайлшгүй арга хэмжээг авах болсон;

2.1.3. үер буусан болон үерийн аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах нөхцөл байдал үүссэн;

2.1.4. ой, хээрийн болон обьектын түймэр гарч байгаль экологи, хот, суурин газрын хүн ам, эд хөрөнгө, барилга байгууламжид аюул учирсан;

2.1.5. бусад тохиолдолд.

2.2. Гамшигаас хамгаалах дайчилгаа зарлах шийдвэрийг баг, хороо, сум, дүүргийн хэмжээнд сум, дүүргийн Засаг дарга, аймаг, нийслэлийн хэмжээнд аймаг, нийслэлийн Засаг дарга гаргана.

2.3. Улсын хил, нийслэлийн болон хэд хэдэн аймгийн нутаг дэвсгэрт гамшигийн аюул үүсэж, цар хүрээ нь тэлсэн, орон нутгийн хүн хүч, техник хэрэгсэл хүрэлцэхгүй болсон үед гамшигаас хамгаалах дайчилгаа явуулах шийдвэрийг Засгийн газар гаргана.



Гурав. Гамшгаас хамгаалах дайчилгааны  
өмнөх үеийн бэлтгэл ажил

3.1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нь гамшгаас хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөнд гамшгаас хамгаалах дайчилгааны арга хэмжээний талаар хавсаргаж жил бүр тодотгол хийнэ. Төлөвлөгөөнд тухайн орон нутгийн газрын зураг, дайчлахаар заасан хүн хүч, техник хэрэгслийн тооцоо, хангарт, зохион байгуулалт, мэргэжлийн ангиудын гүйцэтгэх үүрэг, ажиллах, цугларах газар, хугацааг тодорхой тусгасан байна.

3.2. Аймаг, нийслэлийн онцгой байдлын газар, хэлтэс нь тухайн шатны Засаг даргын Тамгын газартай хамтран гамшгийн үед дайчлах хүн хүч, техник хэрэгсэл, шаардлагатай объект, барилга байгууламж, газар нутгийн судалгаа болон тооцоог гаргаж, гамшгаас хамгаалах дайчилгааны бэлтгэл нөөцдөй бүртгэх ажлыг зохион байгуулсан байна. Дээрх судалгаа, тооцоог гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд хавсаргаж жил бүр тодотгоно.

Дөрөв. Гамшгаас хамгаалах дайчилгааны үеийн  
зохион байгуулалт, удирдлага

4.1. Гамшгаас хамгаалах дайчилгааг зохион байгуулах Засаг даргын үүрэг:

4.1.1. төрийн болон нутгийн захиргаа, аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, иргэдийг дайчлах, гамшгийн хор уршгийг арилгасан үед дайчилгааг цуцлах тухай шийдвэрийг гаргаж хэвлэл мэдээллийн хэрэгслийн мэдээлэх;

4.1.2. гамшгийн нэхцөл байдлыг үнэлж, шийдвэр гаргахдаа гамшгаас хамгаалах дайчилгаа явуулах нэхцөл боломж, гамшгийн голомтын байршил, цар хүрээ, тархалтын байдал, шаардагдах хүч хэрэгслийн тооцоо, үүрэг гүйцэтгэх бүлгүүд, тэдгээрийн гүйцэтгэх үүрэг, ажиллах, цугларах байр, хугацааг тодорхой зааж өгөх;

4.1.3. гамшгийн нэхцөл байдал, хамарсан нутаг дэвсгэр, тархаж болзошгүй чиглэл, үүсэж болзошгүй үр дагавар, гамшиг болсон нутгийн заагийг тогтоосон талаар хөрш зэргэлдээ аймаг, сум, дүүргийн Засаг дарга нарт мэдээлэх;

4.1.4. гамшгаас хамгаалах дайчилгааны үеийн хангалтын (хоол хүнс, ус, шатахуун г.м) зардлыг тухайн орон нутгийн төсвөөс гарган зарцуулах;



4.1.5. автомашин, техникийг дайчлан ажиллуулах үед авто тээврийн цуваа зохион байгуулж, цувааны ахлагчийг томилон бүлгийн зохион байгуулалтад шилжүүлэх;

4.1.6. гамшгаас хамгаалах дайчилгааны үеийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах, эмх замбараагүй байдал гаргуулахгүй байх арга хэмжээг авах;

4.1.7. орон нутгийн төсвөөс давсан зардалтай холбоотой асуудлыг Засгийн газарт уламжлан шийдвэрлүүлэх.

4.2. Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын үүрэг:

4.2.1. дайчилгаа зохион байгуулж байгаа тухайн шатны Засаг даргад мэргэжлийн дэмжлэг үзүүлж, оролцогч байгууллагуудыг удирдлага зохицуулалтаар хангах;

4.2.2. гамшгаас хамгаалах дайчилгааны бэлэн байдлыг хангах зорилгоор дадлага, сургуулийг зохион байгуулах;

4.2.3. гамшгаас хамгаалах дайчилгааны ажлын явц байдал, Засгийн газраас гаргасан шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих;

4.2.4. шаардлагатай гэж үзвэл гамшгаас хамгаалах дайчилгааг зохион байгуулах явцад гарах орон нутгийн төсвөөс давсан зардалтай холбоотой асуудлыг Засгийн газарт уламжлан шийдвэрлүүлэх.

4.3. Аж ахуйн нэгж, байгууллагын үүрэг:

4.3.1. гамшгийн голомтод үүрэг гүйцэтгэхээр дайчлагдах өөрийн байгууллагын хүн хүч, тээврийн хэрэгсэл, барилга байгууламжийн бэлэн байдлыг хангах;

4.3.2. өөрийн байгууллагын дайчлагдсан хүн хүч, техник хэрэгсэл, барилга байгууламжийн мэдээ, гарсан зардлын тайлан тооцоог тухайн шатны Засаг даргын Тамгын газарт танилцуулах;

4.3.3. тухайн шатны Засаг дарга, мэргэжлийн байгууллага, төв, орон нутгийн Онцгой комиссын гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх.

4.4. Иргэний үүрэг:

4.4.1. өөрийн бичиг баримт, хүнс, хувцас хэрэглэлийг бэлтгэж, дайчилгаа зарласан газарт тогтоосон хугацаанд очих;



4.4.2. өөрийн үүрэг, гүйцэтгэх ажлын чиглэлээр жилд нэгээс доошгүй удаа гамшгаас хамгаалах дадлага, сургуульд хамрагдах;

4.4.3. дайчилгааг явуулж байгаа байгууллагын удирдлагын зүгээс тавьсан шаардлага, тогтоосон дэглэм, зөвлөмжийг чанд сахиж мөрдөх;

4.4.4. гамшгаас хамгаалах дайчилгааг зарласан үед тухайн нутаг дэвсгэрээс гадагш албан болон хувийн хэргээр зорчихгүй байх, хүндэтгэн үзэх шалтгаанаар зорчих шаардлага гарсан тохиолдолд оршин суугаа газрын Засаг даргаас зөвшөөрөл авах;

4.4.5. дайчилгаанд хамрагдах багаж хэрэгсэл, техник, тоног төхөөрөмжийг үүрэг гүйцэтгэхэд байнга бэлэн байлгах.

#### Тав. Санхүүжилт, хяналт

5.1. Гамшгаас хамгаалах дайчилгаанд ажилласан иргэний албан тушаалын цалин, ажил эрхлээгүй иргэний хөдөлмөрийн хөлс, бусад нөхөх олговрыг холбогдох хууль тогтоомжийн дагуу олгоно.

5.2. Гамшгаас хамгаалах дайчилгаанд дайчлагдан ажилласан хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн техник хэрэгслийг дайчлан ажиллуулах үеийн шууд зардлыг мөрдөж байгаа жишиг үнийн дагуу тухайн орон нутгийн төсвөөс гаргана.

5.3. Тухайн орон нутгийн төсвөөс давсан зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

5.4. Онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, эрх бүхий бусад байгууллага, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нар эрх хэмжээнийхээ хүрээнд энэхүү журмын хэрэгжилтэд хяналт тавина.

Засгийн газрын 2011 оны 340 дүгээр  
тогтоолын 2 дугаар хавсралт

#### ГАМШГИЙН ҮЕД НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ ЖУРАМ

#### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмаар болзошгүй гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, гамшгийн голомтод байгаа хүн ам, мал, амьтан, эд хөрөнгийг аюулгүй орчинд нүүлгэн шилжүүлэх, байршуулахтай холбогдсон харилцааг зохицуулна.



1.2. “Нүүлгэн шилжүүлэлт” гэж болзошгүй гамшигийн аюулаас урьдчилан сэргийлэх, гамшигийн голомтоосхунам, мал, амьтан, эдхөрөнгийг зохион байгуулалттайгаар аюулгүй орчинд шилжүүлэн байрлуулах арга хэмжээг хэлнэ.

1.3. Гамшигт өртсөн болон өртөж болзошгүй нутаг дэвсгэрээс хүн ам, эд хөрөнгө, мал амьтныг авран хамгаалах зорилгоор гамшигт өртсөн нөхцөл байдлыг харгалзан түр хугацаагаар буюу бүрмөсөн аюулгүй орчинд нүүлгэн шилжүүлэлт хийж болно.

1.4. Энэхүү журмыг бүх шатны Засаг дарга, төрийн болон төрийн бус байгууллага, албан тушаалтан, өмчийн хэлбэр харгалзахгүйгээр аж ахуйн нэгж болон иргэд мөрднө.

Хоёр. Нүүлгэн шилжүүлэлт зарлах тухай  
шийдвэр гаргах

2.1. Нүүлгэн шилжүүлэлт зарлах шийдвэрийг дараахь тохиолдолд гаргана:

2.1.1. газар хөдлөлт болж хот, суурин газар нурж, хүн амьдрах нөхцөлгүй болсон;

2.1.2. тухайн газар нутагт техникийн холбогдолтой осол, дэлбэрэлт, цацраг идэвхт бодис болон химийн хорт бодис алдагдсанаас хүн ам, мал, амьтан амьдрах орчин үгүй болсон;

2.1.3. террорист үйлдлээс урьдчилан сэргийлэх, алан хядах ажиллагааны улмаас үүссэн нөхцөл байдалд зайлшгүй арга хэмжээ авах;

2.1.4. ган, зуд тохиолдох, хот, суурин газар, газар тариалан, мал аж ахуй усны хомсдолд орох ноцтой үр дагавар үүссэн;

2.1.5. үер буусан болон үер, усны аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах нөхцөл байдал үүссэн;

2.1.6. хүн ам, мал, амьтны болон олон улсын хөл хориот халдварт өвчин үүссэн болон уг голомтын зэргэлдээ орших суурин газрын хүн ам, мал, амьтныг урьдчилан сэргийлэх зайлшгүй арга хэмжээг авах болсон;

2.1.7. ой, хээрийн болон обьектын түймэр гарч байгаль экологи, хот, суурин газрын хүн ам, эд хөрөнгө, барилга байгууламжид бодит аюул учирсан.



2.2. Баг, хороо, сум, дүүргийн нутаг дэвсгэрийг хамарч гамшиг үүссэн буюу үүсэж болзошгүй гамшигаас урьдчилан сэргийлэх, аврах ажиллагаа явуулах зорилгоор түр хугацаагаар нүүлгэн шилжүүлэлт явуулах шийдвэрийг тухайн сум, дүүргийн Засаг дарга гаргана.

2.3. Хоёр болон түүнээс дээш сум, дүүргийн нутаг дэвсгэрийг хамарч гамшиг үүссэн буюу үүсэж болзошгүй гамшигаас урьдчилан сэргийлэх, аврах ажиллагаа явуулах зорилгоор түр хугацаагаар нүүлгэн шилжүүлэлт явуулах шийдвэрийг мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн аймаг, нийслэлийн Засаг дарга гаргана.

2.4. Нийслэлийн болон хэд хэдэн аймгийн нутаг дэвсгэрийг хамарч гамшиг үүссэн буюу үүсэж болзошгүй үед түр нүүлгэн шилжүүлэлт явуулах шийдвэрийг Улсын Онцгой комиссын саналыг үндэслэн Засгийн газар гаргана. Бүрмөсөн нүүлгэн шилжүүлэлт явуулахыг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал шийдвэрлэнэ.

2.5. Мэргэжлийн байгууллагын дүгнэлтэд тухайн нутаг дэвсгэрт тохиолдсон гамшигийн эмзэг байдал, бодит аюулын цар хэмжээ, хүн ам, үйлдвэрлэлийн нягтрал, байршил, байгаль цаг уурын нөхцөл, гамшигийн улмаас цаашид гарч болох хор уршгийг тодорхой тусгасан байна.

Гурав. Нүүлгэн шилжүүлэлтийн өмнөх  
үеийн бэлтгэл ажил

3.1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нь гамшигаас хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөнд нүүлгэн шилжүүлэлтийн арга хэмжээний төлөвлөгөөг хавсаргаж, жил бүр тодотгол хийнэ. Төлөвлөгөөнд тухайн орон нутгийн газрын зураг, дайчлахаар заасан хүн хүч, техник хэрэгслийн тооцоо, нүүлгэн шилжүүлэх хүн ам, эд материалын болон соёл, урлагийн үнэт зүйлс, тэдээрийн тоо хэмжээ, хангарт, зохион байгуулалт, мэргэжлийн ангиудын гүйцэтгэх үүрэг, ажиллах, цугларах байр, шилжүүлэх, хүлээн авах байр, хугацааг тодорхой тусгасан байна.

3.2. Нүүлгэн шилжүүлэх шийдвэр гарснаас хойш 3 цагийн дотор цугларах болон хүлээн авах байрууд, нүүн шилжигсдийн тоо, бүртгэлийг хариуцан ажиллах бүртгэл мэдээллийн бүлгийг байгуулсан байна.

Дөрөв. Нүүлгэн шилжүүлэлт

4.1. Нүүлгэн шилжүүлэлт зарласан үед дараахъ ажиллагааг зохион байгуулна:

4.1.1. нүүлгэн шилжүүлэлт явуулах тухай гарсан шийдвэрийг тухайн орон нутгийн албан байгууллага, нийт хүн амд зарлан мэдээлэх;

4.1.2. нүүлгэн шилжүүлэх ажлыг гүйцэтгэх бүлгийн удирдагч нарыг томилон ажилд нь оруулж, эхний ээлжинд аюулгүй бус рүү хүүхэд, эмэгтэйчүүд, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, тэдний гэр бүлийн гишүүд, эд материалын болон түүх, соёл, урлагийн үнэт зүйлсийг нүүлгэн шилжүүлэх арга хэмжээг авч ажиллах;

4.1.3. нүүлгэн шилжүүлэлтэд хамрагдсан хүн амын тоо, бүртгэлийг явуулж, орон байр, хоол хүнсээр хангах, эд материалын болон түүх, соёл, урлагийн үнэт зүйлсийг тээвэрлэлтэд бэлтгэх, байршуулах аюулгүй бус (урьдчилан тогтсон) рүү тээвэрлэх ажлыг зохион байгуулах;

4.1.4. нүүлгэн шилжүүлэлтэд хамрагдсан иргэдийг авто тээвэр болон бусад тээврийн хэрэгслээр цуваанд эмхлэн зохион байгуулж, хэв журам сахиулах бүлгийн хяналт дор нүүлгэнэ. Хэв журам сахиулах бүлэг нь байршуулах бус нутаг хүртэлх замын турш аюулгүй байдлыг хангаж ажиллах;

4.1.5. түр нүүлгэн шилжүүлэлт хийгдсэн үед хот, суурин газрын үлдсэн барилга байгууламж, дэд бүтцийн бүрэн бүтэн байдал, аюулгүй байдлыг хэв журам сахиулах болон харуул хамгаалалтын бүлэг хариуцан ажиллах;

4.1.6. хүн амыг нүүлгэн шилжүүлэх үед бүх төрлийн тээврийн хэрэгслийг тодорхой зааж оноосон бүртгэлийн дагуу дайчилж, бүлэг, хэсэг болгон зохион байгуулж, материал хэрэгслээр ханган хүн ам, эд хөрөнгийг тээвэрлэх ажилд бэлэн болгох.

4.2. Нүүлгэн шилжүүлэх ажлыг удирдаж байгаа Засаг дарга нь дараахь бүлгүүдийг томилж ажиллуулна:

- тээврийн бүлэг;
- эмнэлэг, эрүүл ахуй, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх бүлэг;
- хэв журам сахиулах, зохицуулах бүлэг;
- инженерийн бүлэг;
- нөөцийн материал, орон сууцны хангалтын бүлэг;
- холбоо, мэдээлэл, лавлагааны бүлэг;
- хоол, хүнсний хангалтын бүлэг;
- шатахуун, нефтийн бүтээгдэхүүний хангалтын бүлэг;
- банк, санхүү, нийгмийн хамгааллын бүлэг;
- хүн ам, эд хөрөнгө, мал, амьтныг тоолох иргэний бүртгэл, мэдээллийн бүлэг.

4.3. Бүлгийг тухайн аймаг, нийслэл, сум, дүүргийн орон тооны бус гамшгаас хамгаалах албадын дарга нар удирдах бөгөөд нэг бүлэгт 5-7 хүн байна.



4.4. Энэ журмын 4.1.2, 4.1.3-т заасан эд материалын үнэт зүйл гэдэгт дараах зүйл хамрагдана:

4.4.1. төрийн үнэт зүйл (алт, валютын нөөц, банкны активууд, үнэт цаас, хэмжүүрийн этalon, үнэт металл болон чулууны нөөц, төрийн байгууллагуудын архив, тамга, тэмдэг, албан бичиг, шинжлэх ухааны онцгой чухал баримт бичгүүд, цахим тооцоолох системүүд, өгөгдлийн бааз;

4.4.2. үйлдвэрлэлийн болон шинжлэх ухааны үнэт зүйл (өндөр үнэ бүхий шинжлэх ухааны болон үйлдвэрийн тоног төхөөрөмж, өндөр үнэ бүхий шинжлэх ухааны баримт бичгүүд, цахим сүлжээний баазууд г.м);

4.4.3. хүнсний нөөц, эрүүл мэндийн байгууллагын багаж, тоног төхөөрөмж, эм, эмнэлгийн хэрэгсэл, цус, цусан бүтээгдэхүүний нөөц, ус хангамжийн тоног төхөөрөмж, хүн амын хангалтад зориулагдсан эд материалын нөөц;

4.4.4. хөдөө аж ахуйн мал, амьтан, тарих үр, ургамлын нөөц, үрийн нөөц, бордоо тэжээлийн нөөц;

4.4.5. аврах ажиллагааны болон бусад хойшлуулшгүй сэргээн босгох ажлын үед хэрэглэх багаж, эд материалын нөөц.

4.5. Энэ журмын 4.1.2, 4.1.3-т заасан түүх, соёл, урлагийн үнэт зүйлс гэдэгт дараах зүйл хамрагдана:

4.5.1. Монгол Улсын түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйл;

4.5.2. номын сангийн ховор, үнэт ном судар;

4.5.3. урлагийн үнэт бүтээл;

4.5.4. цахим мэдээллийн сан.

4.6. Эд материалын болон түүх, соёл, урлагийн үнэт зүйлсийн бүртгэлд оруулах шаардлага гарвал соёл, шинжлэх ухааны асуудал хариуцсан төрийн захирагааны төв байгууллагаас мэргэжлийн шинжээч томилж, дүгнэлт гаргуулсан байна.

Тав. Нүүлгэн шилжүүлэх үеийн зохион  
байгуулалт, удирдлага

5.1. Нүүлгэн шилжүүлэлтийг удирдан зохион байгуулах Засаг даргын үүрэг:



5.1.1. нүүлгэн шилжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах тусгай бүлгүүдийн удирдлагыг томилж, бүлгийн гүйцэтгэх үүргийг тодотгож, нүүлгэх ажиллагааг эхлүүлэх;

5.1.2. төрийн болон нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд гамшгаас хамгаалах дайчилгаа, нүүлгэн шилжүүлэлт явуулах шийдвэр гарсан тухай зарлах, гамшгийн хор уршгийг арилгасан тухай шийдвэрийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан нийтэд мэдээлэх;

5.1.3. гамшгийн нөхцөл байдлыг үнэлж, шийдвэр гаргахдаа гамшгаас хамгаалах дайчилгаа явуулах, нүүлгэн шилжүүлэх боломж нөхцөл, гамшгийн голомтын бүс нутаг, цар хүрээ, тархалтын байдал, ажиллах мэргэжлийн анги, хүч хэрэгслийн тооцоо, тэдгээрийн гүйцэтгэх үүрэг, цугларах байр, цаг хугацааг тодорхой зааж өгөх;

5.1.4. гамшгийн нөхцөл байдал, хамарсан нутаг дэвсгэр, тархаж болзошгүй чиглэл, үүсэж болзошгүй үр дагавар, гамшиг болсон нутгийн заагийг тогтоосон тухайгаа хөрш зэргэлдээ аймаг, сум, дүүргийн Засаг дарга наарт нэн даруй мэдээлэх;

5.1.5. нүүлгэн шилжүүлэлтийн үеийн хангалтын (хоол хүнс, ус, шатахуун г.м) зардлыг тухайн орон нутгийн төсвөөс гаргах;

5.1.6. шилжиж ирсэн иргэдийг жагсаалтын дагуу бүртгэн байршуулах нутаг дэвсгэрийн хил хязгаарыг тогтоон өгөх, байршуулж, нүүлгэн шилжүүлэх явцад хүн ам, эд хөрөнгө, мал, амьтны тоо, бүртгэлийн талаар гарсан өөрчлөлтийн мэдээг Улсын Онцгой комисст мэдээлэх;

5.1.7. иргэдийн амьдрах нэн тэргүүний хэрэгцээг хангах (орон байр, ус, хоол хүнс, эмнэлгийн болон сэтгэл зүйн тусламж үзүүлэх, тэдний аюулгүй байдлыг хангах) бүх төрлийн хангалтыг зохион байгуулах;

5.1.8. хүн ам, эд хөрөнгийг тээвэрлэн шилжүүлэх үеийн аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах, эмх замбараагүй байдал гаргуулахгүй байх арга хэмжээг авах;

5.1.9. нүүлгэн шилжүүлэлтэд шаардагдах орон нутгийн төсвөөс давсан зардлыг Засгийн газарт уламжлан шийдвэрлүүлэх;

5.1.10. нүүлгэн шилжүүлэлт хийгдэх үед энэ журмын 4.1-д заасан бүх арга хэмжээг зохион байгуулах.



5.2. Онцгой байдлын асуудал хариуцсан байгууллагын үүрэг:

5.2.1. Гамшигаас хамгаалах тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу нүүлгэн шилжүүлэлтийг удирдан зохион байгуулж байгаа бүх шатны Засаг даргад мэргэжлийн дэмжлэг үзүүлж, оролцогч байгууллагыг удирдлага зохицуулалтаар хангах;

5.2.2. аймаг, нийслэл, дүүргийн Онцгой байдлын газар, хэлтэс нь харьяа нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөөг боловсруулан тухайн шатны Засаг даргаар батлуулж, жил бүр тодотгол хийх;

5.2.3. нүүлгэн шилжүүлэх бэлэн байдлыг хангах зорилгоор дадлага, сургууль зохион байгуулах;

5.2.4. нүүлгэн шилжүүлэлтийг удирдан зохион байгуулж байгаа Засаг даргын Тамгын газар, түүний бүлгүүдийн удирдлага, цугларах болон хүлээн авах байруудыг радио болон хөдөлгөөнт холбооны хэрэгслээр хангах үүрэг хүлээх;

5.2.5. нүүлгэн шилжүүлэлтэд дутагдаж байгаа материал хэрэгслийн нөөцийг хангах ажлыг зохион байгуулах;

5.2.6. нүүлгэн шилжүүлэх ажлын явц байдалд болон Засгийн газраас гаргасан шийдвэр хэрхэн хэрэгжиж байгаад хяналт тавих;

5.2.7. шаардлагатай гэж үзвэл нүүлгэн шилжүүлэлтийг зохион байгуулах явцад гарсан нэмэлт зардлын асуудлыг Засгийн газарт уламжлан шийдвэрлүүлэх.

5.3. Аж ахуйн нэгж, байгууллагын үүрэг:

5.3.1. нүүлгэн шилжүүлэлтэд шаардагдах тээврийн хэрэгслийг гарган дэмжлэг үзүүлэх, үйлдвэрийн тоног төхөөрөмж, байгууллагын эд хөрөнгийг нүүлгэн шилжүүлэхэд бэлтгэх, нүүлгэх, ачих, буулгах ажлыг зохион байгуулах;

5.3.2. өөрийн байгууллагад байгаа материал хэрэгслийн нөөцийг гаргаж зарцуулах;

5.3.3. байгууллагаас дайчлагдсан хүч хэрэгсэл, нүүн шилжигсдийн мэдээ гаргах, нүүлгэн шилжүүлэлтийн явц байдал, гаргасан

зардал, бусад тайлан мэдээг тогтоосон хугацаанд тухайн шатны Засаг даргын Тамгын газарт хүргүүлж танилцуулах;

5.3.4. тухайн шатны Засаг дарга, Улсын Онцгой комиссоос гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх.

5.4. Иргэний үүрэг:

5.4.1. шаардлагатай бичиг баримт, хүнс, хувцас хэрэглэлийг бэлтгэж, цугларах газарт тогтоосон хугацаанд очих;

5.4.2. нүүлгэн шилжүүлэлт хийх бүлгүүдийн удирдлагын зүгээс тавьсан шаардлага, тогтоосон дэглэм, зөвлөмжийг чанд сахиж мөрдөх;

5.4.3. нүүлгэн шилжүүлэлт арга хэмжээг зарласан үед тухайн нутаг дэвсгэрээс гадагш албан болон хувийн хэргээр зорчих шаардлага гарсан тохиолдолд оршин суугаа газрын Засаг даргаас зөвшөөрөл авах, нүүн шилжиж очих газрын хаяг, газар зүйн байрлалыг заалган авах;

5.4.4. сургуулийн өмнөх насны хүүхдийн лавлагаа (овог, нэр, төрсөн он, сар, өдөр, үндсэн хаяг, очих газрын нэр, регистрийн дугаар)-г даавуун дээр бичиж хувцасны дотор талд оёсон байх.

Зургаа. Санхүүжилт, хяналт

6.1. Нүүлгэн шилжүүлэлтийн үеийн зардлыг тухайн орон нутгийн төсвөөс гаргана.

6.2. Тухайн орон нутгийн төсвөөс давсан зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2011 оны 11 дүгээр  
сарын 30-ны өдөр

Дугаар 341

Улаанбаатар  
хот

### “100 мянган айлын орон сууц” хөтөлбөрийг хэрэгжүүлэх тухай

Улсын Их Хурлын 2010 оны 36 дугаар тогтоол, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.4.7 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:



1. “100 мянган айлын орон сууц” хөтөлбөрт хамрагдах Улаанбаатар хот, бүсийн тулгуур төв, аймгийн төвүүдэд эхний ээлжинд баригдах орон сууцны барилга, хотхон, хорооллын жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү тогтоолын хавсралтад заасан орон сууцны барилга, хотхон, хорооллыг барьж байгуулах хөрөнгө оруулагч, аж ахуйн нэгжтэй хэрэгжилтийг хангуулах гэрээ байгуулж, хамтран ажиллахыг Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд Х.Баттулга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

3. “100 мянган айлын орон сууц” хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зорилгоор тус хөтөлбөрт хамрагдсан орон сууцны барилга, хотхон, хороолол болон түүний дэд бүтцийг төлөвлөх, барих, гэр хорооллын газрыг чөлөөлөх ажлыг өөрийн хөрөнгөөр гүйцэтгэсэн аж ахуйн нэгж, хөрөнгө оруулагч болон төсөлд хамрагдсан аж ахуйн нэгж, иргэдэд бага хүйтэй, урт хугацаатай орон сууцны зээл, санхүүжилтийг олгосон банк, санхүүгийн байгууллагыг татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамруулах, мөн аж ахуйн нэгжийн гүйцэтгэсэн ажил, үйлчилгээ, үйлдвэрлэсэн бараа, импортолсон материал, техник, тоног төхөөрөмжийг гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх талаар судалж тодорхой санал боловсруулан 2012 оны 1 дүгээр сарын 31-ний дотор Засгийн газарт оруулахыг Сангийн сайд С.Баярцогт, Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд Х.Баттулга нарт даалгасугай.

4. “100 мянган айлын орон сууц” хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах мэргэжилтэй ажилчдыг аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулсны үндсэн дээр мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвд бэлтгэх талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд Х.Баттулга, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Т.Ганди, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Ё.Отгонбаяр нарт, төслийн хэрэгжилтийг хангах зорилгоор гадаадын зөвлөхүүдийг татан оролцуулах арга хэмжээ авч ажиллахыг Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд Х.Баттулгад даалгасугай.

5. “100 мянган айлын орон сууц” хөтөлбөрт хамрагдсан орон сууцны барилга, хотхон, хороолол, түүний нийгмийн болон инженерийн дэд бүтцийн барилга, байгууламжийг барихад шаардагдах хөрөнгийг “Шинэ бүтээн байгуулалт” дунд хугацааны зорилтот хөтөлбөрт заасан санхүүжилтийн эх үүсвэрээс бүрдүүлэх арга хэмжээг хамтран авч ажиллахыг Сангийн сайд С.Баярцогт, Зам, тээвэр, барилга, хот

байгуулалтын сайд Х.Баттулга, аймаг, нийслэлийн Засаг дарга нар, Монгол Улсын Хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөл (Б.Батжаргал)-д даалгасугай.

6. Хөтөлбөрт хамрагдсан орон сууцны барилга, хотхон, хороолол, түүний дэд бүтцийн барилга байгууламжийн газрыг чөлөөлөх, хамгаалалтад авах, техникийн нөхцөл олгох, зураг төслийг хянаж, зөвшөөрөлцөх, магадлал хийх, барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад оруулах шийдвэрийг шуурхай гарган, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд Х.Баттулга, Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригт, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Р.Содхүү, аймаг, нийслэлийн Засаг дарга наарт үүрэг болгосугай.

7. Энэхүү тогтоолын хавсралтад заасан орон сууцны барилга, хотхон, хорооллыг барьж байгуулах хөрөнгө оруулагч, аж ахуйн нэгжтэй байгуулах гэрээний загварыг батлахыг Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд Х.Баттулгад, мэргэжилтэй ажилчдыг мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвд бэлтгэх гэрээний загварыг батлахыг Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд Х.Баттулга, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Т.Ганди, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Ё.Отгонбаяр наарт даалгасугай.

8. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллан “100 мянган айлын орон сууц” хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг нэгтгэн жил бурийн I, III улиралд багтаан Засгийн газарт танилцуулж байхыг Орон сууцжуулах ажлыг эрчимжүүлэх Үндэсний хороо (М.Энхболд)-нд даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**С.БАТБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН  
ШАДАР САЙД**

**М.ЭНХБОЛД**

**ЗАМ, ТЭЭВЭР, БАРИЛГА,  
ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙД**

**Х.БАТТУЛГА**



Засгийн газрын 2011 оны 341 дүгээр  
тогтоолын хавсралт

**“100 МЯНГАН АЙЛЫН ОРОН СУУЦ” ХӨТӨЛБӨРТ ХАМРАГДАХ  
УЛААНБААТАР ХОТ, БУСИЙН ТУЛГУУР ТӨВ, АЙМГИЙН ТӨВҮҮДЭД  
ЭХНИЙ ЭЭЛЖИНД БАРИГДАХ ОРОН СУУЦНЫ БАРИЛГА,  
ХОТХОН, ХОРООЛЛЫН ЖАГСААЛТ**

№	Төслийн нэр	Байршил	Нийт айлын сууцны тоо	Төслийг хэрэгжүүлэгч иргэн, аж ахуй нэгж, байгууллага
<b>УЛААНБААТАР</b>				
<b>БАЯНГОЛ ДҮҮРЭГ</b>				
1	“Алтай” үйлчилгээ, орон сууцны цогцолбор	БГД, 1-р хороо	430	“Тайгам-Алтай” ХХК, Иргэн Ц, Даваасүрэн
2	“Тэлмүүнхам констракшн” орон сууц	БГД, 2-р хороо	188	“Тэлмүүнхам констракшн” ХХК
3	“Алтан орд өргөө” ХХК	БГД, 4-р хороо	256	“Алтандөл” ХХК
4	“Голден парк” орон сууцны цогцолбор хороолол	БГД, 4-р хороо	4800	“Эко констракшн” ХХК
5	“Ирээдүй” хотхон	БГД, 11-р хороо	843	“Өлзийт Интер Трейд” ХХК
6	“Сайхан” хороолол	БГД, 12-р хороо	185	“Хан-Хайрхан” ХХК
7	90 айлын орон сууцны барилга	БГД, 18-р хороо	90	“Гурван билэг” ХХК
8	“Нарлаг Монгол” орон сууцны хороолол	БГД, 20-р хороо	696	“Инэл” ХХК
9	“Эрин хотхон” орон сууцны хороолол	БГД, 20-р хороо	1789	“Эрин интернэшил” ХХК
10	“Өнөр” хотхон	БГД, 20-р хороо	462	“Номин констракшн” ХХК
<b>БАЯНЗУРХ ДҮҮРЭГ</b>				
11	“The Riverview” хотхон	БЗД, 1-р хороо	500	“Эс энд Ви Юу” ХХК
12	252 айлын орон сууцны хотхон	БЗД, 2-р хороо	252	“Тулга констракшн” ХХК



13	"Баянзүрх Боловсрол" хотхон	БЗД, 2-р хороо	60	"Дэлхий боловсрол" ХХК
14	"Наран" орон сууц	БЗД, 5-р хороо	45	иргэн Г.Нарангэрэл
15	"Сэлэнгэ-888" орон сууцны хороолол	БЗД, 5-р хороо	540	"Ноёд констракшн" ХХК
16	36 айлын орон сууц	БЗД, 5-р хороо	150	"Бридж констракшн" ХХК
17	"Ногоон төгөл" хорооллын 4-р ээлжийн орон сууцны цогцолбор	БЗД, 6-р хороо	309	"Гангар инвест" ХХК
18	90x2 айлын орон сууц	БЗД, 6-р хороо	180	"Си Эм Гэ" ХХК
19	"Ургах наран" хороолол	БЗД, 11-р хороо	5291	"Бльюскай партнэрс" ХХК
20	"Шанхай цэцэрлэгт хороолол"	БЗД, 11-р хороо	3500	"Хонгран сфеко" ХХК
21	Баянзүрх дүүрэг, "Орон сууцны 14-р хороолол"-ын барилгажилтын төсөл	БЗД, 13,14-р хороо	15000	"Кэй энд Ти констракшн" ХХК
22	Түмэн наст	БЗД, 13-р хороолол, 14-р хороо	1380	"Бэрэн констракш энд автомэшн" ХХК
23	"Грийн Ресорт" хотхон	БЗД, 14-р хороо	264	"Грийн ресурс констракшн" ХХК
24	"National Park" орон сууцны хотхон	БЗД, 14-р хороо	1180	"БНЧ" ХХК
25	120 айлын орон сууцны барилга	БЗД, 14-р хороо	120	"Визард констракшн" ХХК
26	"Парк-хаус III" орон сууц	БЗД, 14-р хороо	323	"Заг" ХХК
27	"Тулга констракшн" ХХК-ийн орон сууцны барилга	БЗД, 16-р хороо	50	"Тулга констракшн" ХХК



28	"Нью жуулчин констракшн" ХХК-ийн 60х5 айлын орон сууц	БЗД, 16-р хороо	300	"Нью жуулчин констракшн" ХХК
29	59 айлын орон сууц	БЗД, 16-р хороо	59	Иргэн Б.Ганболд
30	"Инэл" ХХК-ийн үйлчилгээтэй 108 айлын орон сууц	БЗД, 18-р хороо	108	"Инэл" ХХК
31	Иргэн Г.Алтанхуягийн үйлчилгээтэй орон сууц	БЗД, 18-р хороо	70	Иргэн Г.Алтанхуяг
<b>СҮХБААТАР ДҮҮРЭГ</b>				
32	МҮЭ-ийн холбооны 630 айлын орон сууц	СБД, 1-р хороо	630	Монголын Үйлдвэрчний эвлэлийн холбоо
33	345 айлын орон сууцны цогцолбор	СБД, 9-р хороо	345	"Баян зориг" ХХК
34	"100 айл" орон сууцны бичил хороолол	СБД, 10-р хороо	1192	"Гэзэгийн худаг" ХХК
35	"БҮҮХ" орон сууцны цогцолбор	СБД, 11-р хороо	40	"БҮҮХ" ХХК
<b>СОНГИНОХАЙРХАН ДҮҮРЭГ</b>				
36	"Мянганы хотхон" орон сууцны хороолол	СХД, 1-р хороо (Баянголын ам)	10000	"Москва комплекс" ХХК
37	"Орбит" хотхон	СХД, 1-р хороо	1484	"Жарсан" ХХК
38	"Орчлон" хороолол VII ээлж	СХД, 5-р хороо	296	"Орчлон констракшн" ХХК
39	"Хилчин" хотхон	СХД, 7-р хороо	252	Хилийн цэргийн 0119-р анги
40	"Москва" хороолол II ээлж	СХД, 18-р хороо	1378	"Өргөө майнинг" ХХК
41	"G-Star" хотхон	СХД, 18-р хороо	168	"MBC" ХХК
42	Үйлчилгээтэй орон сууц	СХД, 20-р хороо	12	"Боршоон-Ундраа" ХХК



**ХАН-УУЛ ДҮҮРЭГ**

43	Ерөнхийлөгчийн Тамгын газрын ажилтнуудын 70 айлын орон сууц	ХУД, 1-р хороо	70	Ерөнхийлөгчийн Тамгын газар
44	“Пума яармаг” орон сууцны хотхон	ХУД, 4-р хороо	481	“Пума” ХХК
45	“Шинэ гэр” төсөл	ХУД, 4-р хороо	2052	“Пумарийл истэйт” ХХК
46	“Шинэ Яармаг” хороолол	ХУД, 4-р хороо Наадамчдын замын хойно	2450	“Пи Ай Эм Эм” ХХК
47	“Буянт-Ухаа” хороолол	ХУД, 9-р хороо	1764	“Орон сууцны санхүүжилтийн корпораци” ХХК
48	“Анар” хотхон	ХУД, 9-р хороо	378	“Алтан хайрхан оргил” ХХК
49	“Буянт-Ухаа” бичил хороолол	ХУД, 10-р хороо	230	“Модун” ХХК
50	“Маршал” орон сууцны цогцолбор хороолол	ХУД, 11-р хороо	2430	“Эко констракшн” ХХК
51	“Түмэн ганжир” цогцолбор	ХУД, 11-р хороо	240	“Шинэ эхлэл түм” ХХК
52	“Рапид Харш” орон сууцны хороолол	ХУД, 15-р хороо, Төв цэнгэлдэхийн өмнө талд	1359	“Рапид Харш” ХХК, “Хурд групп” ХХК
53	“Апартмент кей эйч” хотхон	ХУД, 15-р хороо	632	“Хурд групп” ХХК
54	Берлин эко хотхон	ХУД, 16-р хороо	1444	Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг (GTZ), ССХОБЗАлба

**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРЭГ**

55	128 айлын орон сууц	ЧД, 3-р хороо	128	Улсын ерөнхий прокурорын газар
	ДҮН		68875	

**БҮСИЙН ТУЛГУУР ТӨВ БОЛОН АЙМГИЙН ТӨВ**

**АРХАНГАЙ**

1	Прокурорын байгууллагын ажилчдын 29 айлын орон сууц	Эрдэнэбулган сум, 2-р баг	58	“Цогт-Өнжүүл” ХХК
---	---	---------------------------	----	-------------------



2	20 айлын орон сууц	Эрдэнэбулган сум, 1-р баг	20	"Эрдэнэбулган хайрхан" ХХК
<b>БАЯНХОНГОР АЙМАГ</b>				
3	"25 айлын сууц" барилга	Баянхонгор сум, 3-р баг	25	"Гал хонгор" ХХК
4	"Хонгор 1000" орон сууцны хороолол	Баянхонгор сум, 3-р баг	160	ГХБГЗГ, "Медтех" ХХК
5	"Хонгор 1000" орон сууцны хороолол	Баянхонгор сум, 3-р баг	40	ГХБГЗГ, "Хөх бүрдний эх" ХХК
<b>ГОВЬСҮМБЭР АЙМАГ</b>				
6	"Шивээ-Овоо" ХК-ийн орон сууц (13-р байр)	Шивээ-Овоо сум, 1-р баг	75	"Шивээ-Овоо" ХК
7	75 айлын орон сууц (12 байр)	Шивээ-Овоо сум, 1-р баг	75	Иргэн Ж.Батбилэг
<b>ДАРХАН-УУЛ АЙМАГ</b>				
8	"Өсөх" орон сууцны хороолол	Дархан сум, 10-р баг, 12-р хороолол	600	"Өсөх-Урам" ХХК
9	"Баяр α" хотхон	Дархан сум, 15-р баг	564	"Альфа констракшн" ХХК
10	30 айлын орон сууц	Дархан сум, 14-р баг	30	"Орон сууцны санхүүжилтийн корпораци" ХХК
11	13-р хороолол	Дархан сум, 12-р баг	2000	"Дархан шар бүрд"ХХК
<b>ДОРНОД АЙМАГ</b>				
12	"Соёмбо" орон сууцны хотхон	Хэрлэн сум, 9-р баг	211	"Билэг" ХХК
13	"Залуус" орон сууцны хороолол	Хэрлэн сум, 1, 8-р баг	535	"Дорнод хийц" ХХК
14	"Чандмань тал" орон сууцны цогцолбор	Хэрлэн сум, 4-р баг	362	"Чандмань тал" ХХК
15	30 айлын орон сууц	Хэрлэн сум, 4-р баг	30	"Орон сууцны санхүүжилтийн корпораци" ХХК



ДУНДГОВЬ АЙМАГ				
16	20 айлын орон сууц	Сайнцагаан сум, 7-р баг	20	“Орон сууцны санхүүжилтийн корпораци” ХХК
ЗАВХАН АЙМАГ				
17	XXI зуун хороолол	Улиастай хот, Өлзийт баг	192	Завхан аймгийн ГХБХБГ
ОРХОН АЙМАГ				
18	2A орон сууцны хороолол	Баян-өндер сум, Согоот баг	1896	“Глобал сивилезейшн” ХХК
ӨВӨРХАНГАЙ АЙМАГ				
19	“Дэлгэрэх хүнс” ХК орон сууцны цогцолбор	Арвайхээр сум, 5-р баг	80	“Дэлгэрэх хүнс” ХК
ӨМНӨГОВЬ АЙМАГ				
20	“Цэций” хороолол	Цогтцэций сум	2150	“М-Си-Эс проперти” хөгжил ХХК
СҮХБААТАР АЙМАГ				
21	“Тэмүүлэл” хотхон	Баруун-Урт сум, 4-р баг	240	“Шарга” ХХК
22	“Green town” орон сууцны хороолол	Баруун-Урт сум, 1-р баг	360	“Хатан туул хөгжил” ХХК
23	30 айлын орон сууц	Баруун-Урт сум, 4-р баг	30	“Орон сууцны санхүүжилтийн корпораци” ХХК
СЭЛЭНГЭ АЙМАГ				
24	Төрийн албан хаагчдын орон сууц	Мандал сум	54	“Тарнийн арцат уул” ХХК
25	Залуус хотхон	Сүхбаатар сум	20	“Сүрлэг харш” ХХК
26	38 айлын орон сууц	Мандал сум, 2-р баг	38	“Орон сууцны санхүүжилтийн корпораци” ХХК
ТӨВ АЙМАГ				
27	“Breezy Homes” орон сууцны хотхон	Зуунмод сум, 6-р баг	200	“Гранд стракч” ХХК
28	30 айлын орон сууц	Зуун мод сум, 1-р баг	30	“Орон сууцны санхүүжилтийн корпораци” ХХК



УВС АЙМАГ				
29	Төрийн албан хаагчдын 16 айлын орон сууц	Улаангом сум	16	Увс аймгийн ГХБХБГ
ХӨВСГӨЛ АЙМАГ				
30	“Хөвсгөл тайсун” ХХК-ийн орон сууцны барилга	Мөрөн сум, 13-р баг	360	“Хөвсгөл тайсун” ХХК
ХЭНТИЙ АЙМАГ				
31	Төрийн албан хаагчдын 60 айлын орон сууц	Хэрлэн сум	120	“Тулга констракшн” ХХК
32	20 айлын орон сууц	Бор-Өндөр сум	20	“Орон сууцны санхүүжилтийн корпораци” ХХК
ДҮН		10611		
НИЙТ		79486		

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2011 оны 11 дүгээр  
сарын 30-ны өдөр

Дугаар 342

Улаанбаатар  
хот

### Төлөвлөгөө батлах тухай

Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах тухай хуулийн 10.1.2-т заасныг үндэслэн Улсын Их Хурлын 2011 оны 11 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөг хавсралт ёсоор баталсугай.

2. Төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллан, биелэлтийг жил бүр Засгийн газарт танилцуулж байхыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Л.Гансүх, Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригт, Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд Х.Баттулга нарт үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД

С.БАТБОЛД

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ  
ЖУУЛЧЛАЛЫН САЙД

Л.ГАНСҮХ

Засийн газрын 2011 оны 342 дугаар  
тогтоолын хавсралт

## НИЙСПЭЛИЙН АГААРЫН БОХИРДЛЫГ БУУРУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хамгийн чадвартай хамгийн чадвартай хамгийн чадвартай	2011 он			2012 он			2013 он			2014 он		
				Үүрийн Хамгийн чадвартай хамгийн чадвартай хамгийн чадвартай			Үүрийн Хамгийн чадвартай хамгийн чадвартай хамгийн чадвартай			Үүрийн Хамгийн чадвартай хамгийн чадвартай хамгийн чадвартай			Үүрийн Хамгийн чадвартай хамгийн чадвартай хамгийн чадвартай		
1	Нийслэлийн агаарын сайджруулах бусин гэр хороолын эрчим хүчиний хэрэгзэний хийнчийн ууранд оройн 18 цагаас өглийн 9 цаг хүртэл сунгах, агаарын бодилдлыг буурулах тухай хүльд зассан айл нэхцэн, айл цадилгаан хүчиний үнийг 50 хувьар буурулах арга хэмжээ авч, зөвүүг үльсэн төсвээс санхүүгуүлэх	1.1. Агаарын чанарыг бусийн тогтоох 1.2. Тухайн бусийн эрчим хүчиний хангас, хэрэгжигээтгэгтогхоо 1.3. Гэр хороолтын цахилгаан дамжуулал болон түээх сүржээг өрөттэх, хүчин ниймждүүлэх тооцоо, судалгаа хийх 1.4.-1.5. Гэр хороолтын цахилгаан дамжуулал болон түээх сүржээг өрөттэх, хүчин ниймждүүлэх 1.5. Цахилгааны шөнийн хэрэглэгэн цаг, хүчин тарифт өөрчилж оруулах 1.6. Нийслэлийн бодхирдлыг буурулах тухай хувьд зассан нахцэл, шалтуур хангасан айл ёрхийг тогтоох 1.7. Дээрх шалтуурыг хангасан айл өрхед цахилгаан эрчим хүчиний үнийг 50 хувьар буурулах арга хэмжээ авч зөвүүг ульсэн төсвээс санхүүгуүлэх	БОДЖЯ НЭДТГ ЭБЭХЯ НЭДТГ ЭБЭХЯ НЭДТГ ЭБЭХЯ НЭДТГ ЭБЭХЯ НЭДТГ ЭБЭХЯ НЭДТГ СЯ, ЭБЭХЯ НЭДТГ												
2	Нийслэлийн агаарын сайджруулах бусин гэр хороолын эрчим хүчиний хөгжлийн зоруулж байгууллагад оптох шийдвэрийн гарах	2.1. Гэр хорооллын айл өрхийн цахилгаан эрчим хүчиний хөгжлийн зоруулж байгууллагад оптох шийдвэрийн хүчиний байгууллагад оптох													



3	Нийтэлэлийн агаарын чанарыг сайжруулах бүсэд оршиж суугаа тоог гарж, яилж, төрөлжин сан болгох болготой	3.1. Агаар бодиждуулалч эх Усварийн нэгдэн явуулж, чадлыг мэдээллийн санд оруулах	Шинэ эх Усварь барьж байгуулах техники-эдийн засгийн төслийг зураг	БОАЖА	НЭДЛГ	1/X-15/XI								
4	Эрчим хүчинчийн үйлдвэрлэлийн шинэ эх Усварь 5, 6 дугаар цахигтан станцыг барьж, эхийн эзжийг оруулж 2014 онд дусгах	4.1. Хүчинчийн шинэ эх Усварь барьж байгуулах техники-эдийн засгийн төслийг зураг	БЕЭХЯ	НЭДЛГ	1/X-15/XI	10/VIII	15/XII	10/X	15/XI	1/X-15/XI	10/VIII	15/XII	1/X-15/XI	
5	Нийтэлэлийн агаарын бодиждлыг бууруулахад шаардлагах хөрөнгийн номээлтэй Усварийн бодиждлыг бууруулахад хөрөнгийн застийн газрын бодиждлыг бууруулахад хөрөнгийн эзэл олгох, санхүүгийн бусад эх Усварийн дайчах шиндвэрлэх	5.1. Нийтэлэлийн бодиждлыг бууруулахад хөрөнгийн шиндвэрлэхэд шаардлагадах хамжээг тохиох	БЕЭХЯ	СЯ, ЗТЕХБЯ	1/X-15/XI	10/VIII	15/XII	10/X	15/XI	1/X-15/XI	10/VIII	15/XII	1/X-15/XI	
6	Нийтэлэлийн павсрэгт байх нам даравалтын зуухыг хэсэгчилжсан	6.1. Нутаг даравалтын хэсэгчилжсан даравалтын зуухыг	ЗЧУҮГ СИСТЕМД ШИНЭЧЛЭЛ	ЭБЭХЯ	ЗТЕХБЯ	1/X-15/XI	10/VIII	15/XII	10/X	15/XI	1/X-15/XI	10/VIII	15/XII	1/X-15/XI



7	халаалтын системд цахилгдан холбогдох, эрчим хүч болон хүй, хаксон тулшиний эх халвах уусээрээр технологийн шинчилгээнд хийдээрүүг нам дараалтын халаалтын зуучыг кокон тулшыэр хантах	6.2. Хэсэгчилсан халаалтын системд технологийн шинчилгээнд хийдээрүүг нам дараалтын халаалтын зуучыг кокон тулшыэр хантах	ЭБЭХЯ НЭДТГ											
6.3. "ДЦС-2"-ыг түүтийнэн 210 мянган тн хагас хаксон тулш уйлдвэрлэлт хүчин чадал бүхий цэргийн байгууллах	210 мянган тн хагас хаксон тулш уйлдвэрлэлт хүчин чадал бүхий цэргийн байгууллах													
Агаарын бөхийрдлын эх үүсээр, серег талбар ирээдэд ухуулан, таниуллах, ахийн хэрэгзээнд шатраг хий ашиглах, эдээрлийг талбар хэрэглэж, ашиглах, агуулгүй талбар олгох, сургалт, сургалчилгаа хийх	7.1. Ахийн хэрэгзээнд шатраг хий ашиглах, агуулгүй хэрэглэх талбар шедлагт олгох, сургалт зохион байгууллах													
7.2. Хийн тулш ашиглах гарийн зуух бүтэж тусвих, түршилтн үр дүнд түүтийнэнд түршилт гаргах хувцас авах байндай анхилагайтай хэрэгжүүлэх боломжий, саналыг санаалыг холбогдол ичдээрэй түршилтуулж урамшууллах тогтолцоог буудуулж														
7.3. Ирээдийн саналыг тогтолцох хувцас авах байндай анхилагайтай хэрэгжүүлэх боломжий, санаалыг холбогдол ичдээрэй түршилтуулж урамшууллах тогтолцоог буудуулж	7.3. Ирээдийн саналыг тогтолцох хувцас авах байндай анхилагайтай хэрэгжүүлэх боломжий, санаалыг холбогдол ичдээрэй түршилтуулж урамшууллах тогтолцоог буудуулж													
7.4. Агаар болон хүний биологийн сорцын дахь химийн бодисын хамжээг тодорхойлох Ниймийн эрүүл мэндийн хуралдаанын Хор судалжлын тогтолцоог тоног төхөөрөмжийн шинчилгээний судалжлын лабораторийн тоног тогтолцоог түршилтуулж урамшууллах тогтолцоог буудуулж														
Гадаад орчуудад хэрэглэгдэг агаарын бодисын хамжээг тодорхойлох Ниймийн эрүүл мэндийн хуралдаанын Хор судалжлын лабораторийн тогтолцоог түршилтуулж урамшууллах тогтолцоог буудуулж	8.1. Утасан хэшиг, мананг салхин сийсний агаар үзэлтэн арилгадаг түршилтуулж урамшууллах тогтолцоог буудуулж													
8.2. Гадаад орны түршилтийн монголын нэхцэлдэг түршилтийн төсөл хэрэгжүүлэх агаарын сийсний арилгагай судалж, талбар агаарын хамжээ авах	8.2. Гадаад орны түршилтийн монголын нэхцэлдэг түршилтийн төсөл хэрэгжүүлэх агаарын сийсний арилгагай судалж, талбар агаарын хамжээ авах													



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2011 оны 11 дүгээр  
сарын 30-ны өдөр

Дугаар 344

Улаанбаатар  
хот

### Журам батлах тухай

Татварын өрөнхий хуулийн 38.4-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь :

- “Татварын улсын байцаагчид ажлын үр дүнгийн шагнал олгох журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.
- Татварын улсын байцаагчид олгох ажлын үр дүнгийн шагналын хөрөнгийг Татварын өрөнхий газрын жил бүрийн төсөвт тусгаж байхыг Сангийн сайд С.Баярцогтод үүрэг болгосугай.
- Энэхүү тогтоолыг 2012 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД

С.БАТБОЛД

САНГИЙН САЙД

С.БАЯРЦОГТ

Засгийн газрын 2011 оны 344 дүгээр  
тогтоолын хавсралт

### ТАТВАРЫН УЛСЫН БАЙЦААГЧИД АЖЛЫН ҮР ДҮНГИЙН ШАГНАЛ ОЛГОХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь татварын улсын байцаагчийн ажлыг дүгнэн, ажлын үр дүнгийн шагнал олгох харилцааг зохицуулахад оршино.

1.2. Татварын улсын байцаагчийн ажлын үр дүнг сар тутам дүгнэж, шагнал олгож болно.

1.3. Сар тутам олгох ажлын үр дүнгийн шагналын хэмжээ нь тухайн улсын байцаагчийн сарын үндсэн цалингийн 30 хүртэл хувиас хэтрэхгүй байна.

1.4. Татварын улсын байцаагчид ажлын үр дүнгийн шагнал олгох хөрөнгийн нийт хэмжээ нь татварын улсын байцаагчдын жилийн үндсэн цалингийн сангийн 25 хувиас хэтрэхгүй байна.

Хоёр. Үр дүнгийн шагнал олгох

2.1. Ажлын үр дүнгийн шагналыг олгоходо татварын улсын байцаагчийн ажлын байрны тодорхойлолтод заасан ажил, үүргийн биелэлтийг үндэслэнэ.

2.2. Татварын улсын байцаагчийн ажил, үүргийн биелэлтийг дүгнэх журмыг Татварын ерөнхий газрын даргын тушаалаар батална.

2.3. Татварын улсын байцаагчийн үр дүнгийн шагналыг олгоходо Татварын ерөнхий газрын даргын тушаалаар баталсан журмыг үндэслэн дүгнэж, тухайн байгууллагын даргын шийдвэрээр сар бүр олгоно.

Гурав. Бусад зүйл

3.1. Сахилгын шийтгэл хүлээсэн татварын улсын байцаагчид сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа хүртэл ажлын үр дүнгийн шагнал олгохгүй.

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2011 оны 11 дүгээр  
сарын 30-ны өдөр

Дугаар 345

Улаанбаатар  
хот

### Журам батлах тухай

Гаалийн тухай хуулийн 280.5-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Гаалийн улсын байцаагчид ажлын үр дүнгийн шагнал олгох журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.



2. Гаалийн улсын байцаагчид олгох ажлын үр дүнгийн шагналд шаардагдах хөрөнгийг Гаалийн ерөнхий газрын жил бүрийн төсөвт тусгаж байхыг Сангийн сайд С.Баярцогтод үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоолыг 2012 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД

С.БАТБОЛД

САНГИЙН САЙД

С.БАЯРЦОГТ

Засгийн газрын 2011 оны 345 дугаар  
тогтоолын хавсралт

**ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧИД АЖЛЫН  
ҮР ДҮНГИЙН ШАГНАЛ ОЛГОХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь гаалийн улсын байцаагчийн ажлыг дүгнэн, ажлын үр дүнгийн шагнал олгох харилцааг зохицуулахад оршино.

1.2. Гаалийн улсын байцаагчийн ажлын үр дүнг сар тутам дүгнэж, шагналыг улиралд нэг удаа олгоно.

1.3. Ажлын үр дүнгийн шагналын хэмжээ нь тухайн гаалийн улсын байцаагчийн улирлын үндсэн цалингийн 30 хүртэл хувиас хэтрэхгүй байна.

1.4. Гаалийн улсын байцаагчийн ажлын үр дүнгийн шагнал олгох хөрөнгийн нийт хэмжээ нь гаалийн улсын байцаагчдын жилийн үндсэн цалингийн сангийн 25 хувиас хэтрэхгүй байна.

Хоёр. Шалгуур үзүүлэлт

2.1. Гаалийн улсын байцаагчид ажлын үр дүнгийн шагнал олгоход дор дурдсаныг харгалзана:

2.1.1. улирлын ажлын үр дүнгийн гэрээний биелэлт, хариуцсан ажлаа гүйцэтгэх чадвар, мэргэшлийн түвшин нь өссөн байдал;

2.1.2. гаалийн хяналт, бүрдүүлэлтийн ажлын чанар, үр нөлөөг дээшлүүлэхэд гаргасан санаачилга, үр дүн;



2.1.3. гаалийн улсын байцаагчийн ёс зүй, харьцааны соёл, үйлчлүүлэгчийн зүгээс өгсөн үнэлгээ;

2.1.4. гаалийн хууль тогтоомжийг сурталчлах, зөвлөгөө өгөх, гаалийн зөрчлийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр хийсэн ажлын үр дүн;

2.1.5. гаалийн улсын байцаагчийн гүйцэтгэх чадварын өсөлт, дээд байгууллагын шийдвэр болон удирдлагаас өгсөн үүрэг, даалгаврын биелэлтийг хангасан байдал, үр дүн.

2.2. Ажлын үр дүнгийн шагналыг олгохдоо энэ журмын 2.1-д заасан шалгуур үзүүлэлтийн биелэлтийг үндэслэх бөгөөд шалгуур үзүүлэлт дүгнэх журмыг гаалийн удирдах төв байгууллагын дарын тушаалаар батална.

#### Гурав. Бусад зүйл

3.1. Сахилгын шийтгэл хүлээсэн гаалийн улсын байцаагчид сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа хүртэл ажлын үр дүнгийн шагнал олгохгүй.

#### Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн редакци.  
Улаанбаатар-12, Төрийн ордон 124 тоот  
И-мэйл: turiin\_medeel@parliament.mn

Утас: 262420, 329612  
Хэвлэлийн хуудас: 2.75  
Индекс: 14003